



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 06 өдөр

Дугаар #11

Чойбалсан

Г Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай зөвлөмж, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/29 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 31 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 33 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 32 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үеийн нөхцөл байдал хүндэрч сэжигтэй тохиолдол бүртгэгдэн Матад болон Хэрлэн сумыг шар түвшинд шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нарт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

-Коронавируст халдвар /Ковид-19/ тухайн орон нутгийн хүн амын дунд тархах эрсдэлийг үнэлэн, халдвараас сэргийлэх, цар тахлын үед үүссэн нөхцөл байдалд тохируулан эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж мөрдөгдөж байгаа тушаал, шийдвэр, журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх,

-Коронавируст халдвар /Ковид-19/-ын лабораторийн шинжилгээнд сорьц авах, хадгалах, зөөвөрлөх, хийх давтамж, төрөл, мэдээллийн чанар, био аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс сэргийлэх

-Харилцаа холбоо, зарлан мэдээлэх, мэдээллийн урсгалын бэлэн байдлыг хангах, шуурхай арга хэмжээнд эрүүл мэндийн ажилтан бүрийг сургаж дадлагажуулах,

-Хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгсэл болон бусад хэрэгцээг тооцоолон нөөцийг бүрдүүлэх,

-Эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналтыг батлагдсан зааврын дагуу камерын хяналтанд хатуу чанга мөрдөж ажиллах нөхцлийг бүрдүүлэх,

-Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан бүрийг холбогдох зааврын дагуу хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хамгаалах хувцас хэрэгслийг өмсөж тайлах дадлыг эзэмшүүлэх сургалтыг тасралтгүй тогтмол зохион байгуулах, голомтонд ажиллах багийг давтан сургах,

31820096

-Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгчийн эрэмбэлэн ангилалтыг сайтар хийж, сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн нөхцөлд бусад үйлчлүүлэгчтэй холихгүй байх урсгал хөдөлгөөний зохицуулалт хийх,

-Эмнэлэгт ирж буй үйлчлүүлэгч бүрээс тархвар судлалын асуумж авч, эмнэлэгт суурилсан тандалтыг өргөжүүлэх,

-Коронавируст халдвар /Ковид-19/ -ын үеийн тусгаарлан ажиглах, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах,

-Эмч, эмнэлгийн ажиллагсдын бөөгнөрөл үүсгэхгүй, хүн хоорондын зай барьж халдвар хамгааллыг чанд мөрдөж ажиллах,

-Хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх сурталчилгаа мэдээллийг эрчимжүүлэх.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс /Я.Эрдэнэтуяа/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг/, Нийгмийн эрүүл мэндийн төв /Б.Сарнай/ нарт даалгасугай.

ДАРГА  Ч.ОЮУНАА

